

АГУУЛГА

| | |
|--|-----------|
| МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ..... | 2 |
| НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ..... | 4 |
| 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: | 4 |
| 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: | 7 |
| ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ..... | 9 |
| 2.1. Нэгдсэн төсвийн орлого: | 10 |
| 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага: | 12 |
| 2.3. Төсвийн тэнцэл: | 13 |
| ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА | 15 |
| 3.1 Гадаад худалдааны эргэлт:..... | 15 |
| 3.2 Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн | 17 |
| 3.3 Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн | 19 |
| ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ | 21 |
| 4.1. Мөнгөний нийлүүлэлт:..... | 21 |
| 4.2. Гадаад валютын албан нөөц:..... | 23 |
| 4.3. Төлбөрийн тэнцэл:..... | 24 |
| ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ..... | 26 |
| 5.1. Хүн ам, ажил эрхлэлт: | 26 |

**МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ**

КОВИД-19 вирусын тархалт үргэлжилж, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл өөрчлөгдсөнөөр эдийн засгийн өсөлт 2020 оны эхний гурван улиралд огцом саарч макро түвшний голлох үзүүлэлтүүд буурч эдийн засаг агшихад нөлөөлж байна.

- **Эдийн засгийн өсөлт огцом буурчээ.** ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар 1.4 хувьд буюу хамгийн доод цэгтэй хүрч байсан. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны нэгдүгээр улирлаас огцом буурч -10.7 хувь буюу хамгийн доод хэмжээндээ хүрч, хоёрдугаар улирлын байдлаар -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан байна.

- **Нэгдсэн төсвийн тэнцэл алдагдалтай гарсан байна.** 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,845.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -7.0 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,330.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол төлөвлөсөн дүнгээс 1,288.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,595.1 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14.9 хувь буюу 1,153.9 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 7.5 хувь буюу 534.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 11,263.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 83.8 хувийг ашиглаж, 1,823.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 2,176.3 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар өсч 9,440.7 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

- **Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан боловч өмнөх оны мөн үеэс буурчээ.** Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан боловч энэ оны 3 дугаар улирлыг өнгөрсөн оны мөн үетэй харицуулахад 128.4 сая ам.доллороор буурч 1,218.9 сая ам.долларын ашигтай гарчээ. Тэнцэл 9.5 хувиар буурахад экспортын 799.1 сая ам. долларын бууралт, импортын 670.7 сая ам.долларын бууралт тус тус нөлөөлсөн байна.

- **Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлт 2020 оны гуравдугаар улирлын байдлаар 22,425.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1,993.0 тэрбум төгрөг буюу 9.8 хувиар өссөн байна.

- **Хэрэглээний үнийн индекс буурлаа.** Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 09 дүгээр сарын эцэст 1.7 хувь болж өмнөх сараас 0.4 пунктээр, өмнөх оны мөн үеэс 7.3 пунктээр тус тус буурсан байна.

- **Гадаад валютын нөөц буурлаа.** Гадаад валютын нөөцийн хэмжээ 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 3,697.8 сая ам.долларт хүрээд байна. Нөөцийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 287.8 сая ам.доллар буюу 7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- **Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа.** 2020 оны гуравдугаар улирлын байдлаар урсгал тэнцэл 741.6 сая ам.долларын, төлбөрийн тэнцэл 472.5 сая ам.долларын тус тус алдагдалтай гарсан байна.

- **Үнэт цаасны арилжаа буурчээ.** Үнэт цаасны арилжаагаар 2020 оны 09 дүгээр сарын эцэст нийт 210.1 сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, 34.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 73.2 хувиар буурсан байна.

- **Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан байна.** 2020 оны 09 дүгээр сарын эцэст Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,854.2 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.1 хувиар, оны эхнээс 3.7 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 419.0 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, оны эхнээс 5.7 хувиар тус тус суларсан байна.

- **Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна.** Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 09 дүгээр сарын эцэст 1,147.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 161.5 тэрбум төгрөг буюу 16.4 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.6 хувь, хэвийн зээлийн 8.1 хувийг тус тус эзэлжээ.

--oOo--

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

Эцсийн ашиглалтын аргаар: 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр оны үнээр Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 26.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөг буюу 1.4 хувиар буурсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн¹ нь 2016 оны мөн үед 17.1 их наяд, 2017 оны мөн үед 20.2 их наяд, 2018 оны мөн үед 23.3 их наяд, 2019 оны мөн үед 27.2 их наяд төгрөгт хүрч, тасралтгүй өсөлттэй байсан бол 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 26.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ.

Нэрлэсэн ДНБ-ий дүн буурахад эцсийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 1.6 их наяд төгрөгөөр, цэвэр экспорт 1.0 их наяд төгрөгөөр өссөн ч, хөрөнгийн хуримтлал 2.9 их наяд төгрөг буюу 29.6 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Эцсийн ашиглалтын аргаар: 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 12.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна.

¹ - эцсийн ашиглалтын аргаар оны үнээр тооцоход

График 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зэрэгцүүлэх үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн² нь 2016 оны мөн үед 11.4 их наяд, 2017 оны мөн үед 12.0 их наяд, 2018 оны мөн үед 12.7 их наяд, 2019 оны мөн хугацаанд 13.7 их наяд төгрөгт хүрч байсан бол 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 12.7 их наяд төгрөг болж, 7.1 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ.

ДНБ-ий үзүүлэлт буурахад эцсийн хэрэглээ 0.7 их наяд төгрөг буюу 7.1 хувиар, цэвэр экспорт 0.2 их наяд төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн боловч хөрөнгийн хуримтлал 2.0 их наяд төгрөг буюу 33.6 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

ДНБ-ийг улирлаар харуулбал жил бүрийн нэгдүгээр улиралд ДНБ-ий хэмжээ тухайн жилийн хамгийн бага утгыг үзүүлдэг бол хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2016-2020 оны гуравдугаар улирлын үзүүлэлтүүдийг 5 жилийн дунджаар авч үзвэл эцсийн хэрэглээ ДНБ-ий 66.3 хувийг, хөрөнгийн нийт хуримтлал 32.2 хувийг, цэвэр экспорт 1.5 хувийг эзэлсэн байна.

График 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

² - эцсийн ашиглалтын аргаар 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцоолоход

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр ДНБ-ий 67.1 хувь нь эцсийн хэрэглээнд, 20.4 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, 12.4 хувь нь цэвэр экспортод ногдож байна.

Үйлдвэрлэлийн аргаар: Нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 26.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөг буюу 3.5 хувиар, зэрэгцүүлэх үнээр 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна. Үүнд аж үйлдвэр 0.08 их наяд, үйлчилгээ 0.4 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.1 их наяд төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ийг өссөн дүнгээр өмнөх онтой харьцуулахад хөдөө аж ахуй 0.5 их наяд, үйлчилгээний болон худалдаа 0.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн ч, аж үйлдвэр 1.2 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.3 их наяд төгрөгөөр тус тус буурсан байна.

ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр


Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

| Бүрэлдэхүүн | 2016Q3 | 2017Q3 | 2018Q3 | 2019Q3 | 2020Q3 | Зөрүү |
|--|----------|----------|----------|----------|----------|----------|
| ДНБ | 17,250.2 | 20,370.4 | 23,881.7 | 27,399.7 | 26,446.2 | -953.5 |
| Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур | 2,355.8 | 2,397.3 | 2,932.1 | 3,084.1 | 3,554.5 | 470.5 |
| Уул уурхай, олборлолт | 3,001.0 | 4,686.1 | 5,545.5 | 6,447.2 | 5,203.9 | -1,243.3 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 1,290.0 | 1,693.3 | 2,098.2 | 2,294.4 | 2,270.4 | -24.0 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 403.4 | 411.0 | 471.8 | 525.8 | 566.3 | 40.5 |
| Барилга | 567.5 | 510.5 | 578.2 | 674.1 | 662.1 | -12.0 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ | 1,384.8 | 1,590.8 | 1,761.0 | 2,132.2 | 1,947.7 | -184.5 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 973.8 | 1,107.6 | 1,251.2 | 1,383.9 | 1,087.1 | -296.8 |
| Мэдээлэл, холбоо | 360.8 | 348.6 | 407.9 | 473.5 | 504.8 | 31.3 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 5,325.1 | 5,614.3 | 6,050.0 | 7,164.1 | 7,730.2 | 566.0 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 1,588.0 | 2,010.8 | 2,785.8 | 3,220.4 | 2,919.3 | -301.1 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 26.4 их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 47.3 хувийг үйлчилгээ, 28.3 хувийг аж үйлдвэр, 13.4 хувийг хөдөө аж ахуй, үлдэх 11.0 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлсэн байна.



2020 оны гуравдугаар улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар ДНБ-ийг оны үнээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбар 20.3 хувиар, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 9.7 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 9.3 хувиар тус тус буурсан бол хөдөө аж ахуйн салбар 15.3 хувиар өссөн байна.

1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,917.1 мянган төгрөг болж, энэ үеэс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өсөх хандлагаа хадгалсан хэвээр байж 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр ДНБ-ий өсөлт 5.2 хувьд хүрэх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,680.6 мянган төгрөг буюу хамгийн өндөр утгандаа хүрчээ. 2019 оны байдлаарх нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2017 оны мөн үеэс 29.8 хувь буюу 2,681.5 мянган төгрөгөөр, 2018 оны мөн үеэс 13.8 хувь буюу 1,420.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар 1.4 хувьд буюу хамгийн доод цэгтээ хүрсэн байна. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны нэгдүгээр улирлаас огцом буурч -10.7 хувь буюу хамгийн доод хэмжээндээ хүрч, хоёрдугаар улирлын байдлаар -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 2016-2020 оны гуравдугаар улирлын төлөвийг авч үзвэл тус хугацаанд жил дараалан өссөн дүнтэй байсан бол 2020 оны гуравдугаар улирлын байдлаар -7.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурчээ. Үүнд салбаруудын оролцооны нөлөөллийг авч үзвэл уул уурхай, олборлолт, бүтээгдэхүүний цэвэр татвар болон үйлчилгээний салбар тус тус тодорхой хувиар буурсан нь нөлөөлж нийт эдийн засаг агшсан. ДНБ 7.3 хувийн бууралттай байгаа нь уул уурхай, олборлолтын салбар 20.7 хувиар, үйлчилгээ 7.0 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татвар 8.4 хувиар тус тус өмнөх оны мөн үеэс буурсантай холбоотой байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,595.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 9,440.7 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,845.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 534.8 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 7.5 хувиар дутуу биелсэн бол төсвийн нийт зарлага 1,823.0 тэрбум төгрөг буюу 16.2 хувиар төлөвлөснөөс дутуу зарцуулагджээ.

Монгол Улсын нэгдсэн төсөв

Хүснэгт 2.

/тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт (+/-) | |
|--|-----------------------------|-------------|----------------|---------|
| | 1 | 2 | (2-1) | (2-1)/1 |
| | 2020 оны гуравдугаар улирал | | Зөрүү | Хувь |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 7,129.9 | 6,595.1 | -534.8 | -7.5 |
| Нийт зарлагын дүн | 11,263.7 | 9,440.3 | -1,823.0 | -16.2 |
| Тэнцвэржүүлсэн тэнцэл | -4,133.8 | -2,845.6 | 1,288.2 | 31.2 |
| Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | -10.2 | -7.0 | | |

Эх сурвалж: Сангийн яам

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,595.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,153.9 тэрбум төгрөг буюу 14.9 хувиар буурсан бол нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 9,440.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2,176.3 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар өссөн байна.

Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2016-2020 оны гуравдугаар улирлын байдлаар

Хүснэгт 3.

/тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | Жил бүрийн гуравдугаар улирлын гүйцэтгэлээр | | | | | Өөрчлөлт(+/-) | |
|--|---|---------|---------|---------|----------|---------------|----------|
| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 4,012.7 | 5,035.1 | 6,516.7 | 7,749.0 | 6,595.1 | -800.1 | -16.3 |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 6,064.4 | 5,773.0 | 6,275.0 | 7,264.4 | 9,440.3 | 1,590.0 | 33.8 |
| Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл | -2,051.7 | -737.9 | 241.7 | 484.6 | -2,845.6 | -2,390.2 | -1,243.9 |
| Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | -8.5 | -2.7 | 0.8 | 1.4 | -7.0 | | |

Эх сурвалж: Сангийн яам

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,845.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч энэ нь өмнөх оны мөн үеэс 3,330.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь -7.0 хувь болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ДНБ-д эзлэх алдагдлын хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 2,845.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -7.0 хувьд хүрсэн нь төлөвлөсөн дүнгээс 1,288.3 тэрбум төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан үзүүлэлт юм.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөсөнд хүрч биелээгүй ч нийт зарлага хэмнэгдэж зарцуулагдсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал төлөвлөснөөс буурахад нөлөөлжээ.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,595.1 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14.9 хувь буюу 1,153.9 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 7.5 хувь буюу 534.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.7 хувийг татварын орлого, 9.3 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 14.2 хувь буюу 771.1 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсөв 11.5 хувь буюу 301.1 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 15.0 хувь буюу 56.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн бол Нийгмийн даатгалын сангийн төсөв 17.7 хувь буюу 216.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс давж биелсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 17.7 хувь буюу 999.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 18.5 хувь буюу 325.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 4.6 хувь буюу 15.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол орон нутгийн төсвийн орлого 11.2 хувь буюу 232.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/

| Ангилал | Улсын төсөв | | Орон нутгийн төсөв | | НДС | | ЭМДС | |
|--|----------------|----------------|--------------------|----------------|--------------|----------------|--------------|--------------|
| | Төлөв. | Гүйцэт. | Төлөв. | Гүйцэт. | Төлөв. | Гүйцэт. | Төлөв. | Гүйцэт. |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 6,048.8 | 5,271.8 | 2,613.7 | 2,312.6 | 1,220.0 | 1,436.4 | 380.1 | 323.2 |
| ИРЭЭДҮЙН ӨВ САН | 569.1 | 586.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 52.0 | 28.7 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 5,427.8 | 4,656.7 | 2,613.7 | 2,312.6 | 1,220.0 | 1,436.4 | 380.1 | 323.2 |
| Татварын орлого | 4,383.4 | 4,009.2 | 1,076.5 | 850.7 | 860.0 | 1,076.4 | 380.1 | 323.2 |
| Орлогын албан татвар | 1,171.1 | 891.6 | 719.5 | 562.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Нийгмийн даатгалын орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 860.0 | 1,076.4 | 380.1 | 323.2 |
| Хөрөнгийн албан татвар | 0.0 | 0.0 | 140.5 | 114.2 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 1,658.5 | 1,618.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Онцгой албан татвар | 604.6 | 580.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тусгай зориулалтын орлого | 11.7 | 12.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Гадаад үйл ажиллагааны орлого | 588.9 | 550.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 348.8 | 355.7 | 216.5 | 173.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Татварын бус орлого | 1,044.4 | 647.5 | 1,537.2 | 1,462.0 | 360.0 | 360.0 | 0.0 | 0.0 |
| Нийтлэг татварын бус орлого | 448.8 | 385.5 | 180.9 | 141.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хөрөнгийн орлого | 0.0 | 0.0 | 0.7 | 0.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тусламжийн орлого | 281.2 | 238.0 | 6.4 | 4.7 | 360.0 | 360.0 | 0.0 | 0.0 |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 314.3 | 24.0 | 1,349.2 | 1,315.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 5,984.3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 6.5 хувь буюу 418.8 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Татварын орлогын 24.3 хувийг орлогын албан татвар, 18.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.9 хувийг хөрөнгийн албан татвар, 27.1 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.7 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 9.2 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого 418.8 сая төгрөгөөр тасалдахад нийгмийн даатгалын орлого болон тусгай зориулалтын орлогоос бусад төрлийн татварын орлого дутуу төвлөрсөн нь нөлөөлсөн байна. Үүнд: орлогын албан татвар 23.1 хувь /436.0 тэрбум төгрөг/, хөрөнгийн албан татвар 18.7 хувь /26.3 тэрбум төгрөг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 2.4 хувь /39.6 тэрбум төгрөг/, онцгой албан татвар 4.0 хувь /24.1 тэрбум төгрөг/, гадаад үйл ажиллагааны орлого 6.6 хувь /38.7 тэрбум төгрөг/, бусад татвар, төлбөр хураамж 6.4 хувь /36.0 тэрбум төгрөг/-иар тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ. Харин нийгмийн даатгалын орлого 19.2 хувь /181.3 тэрбум төгрөг/, тусгай зориулалтын орлого 5.3 хувь /0.6 тэрбум төгрөг/-иар төлөвлөгөөг тус тус давуулан биелүүлсэн байна.


Дутуу төвлөрсөн татварын орлогын 73.2 хувийг орлогын албан татвар, 6.3 хувийг онцгой албан татвар, 10.1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 10.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр татварын орлого 1,026.9 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар буурахад орлогын албан татвар 330.9 тэрбум (18.5%), нийгмийн даатгалын орлого 290.2 тэрбум (20.5%), хөрөнгийн албан татвар 1.7 тэрбум (1.4%), нэмэгдсэн өртгийн албан татвар 146.9 тэрбум (8.3%), онцгой албан татвар 74.7 тэрбум (11.4%), гадаад үйл ажиллагааны орлого 33.4 тэрбум (5.7%), бусад татвар, төлбөр, хураамж 149.4 тэрбум (22.0%) төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Татварын бус орлого 610.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 17.2 хувь буюу 127.0 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 116.0 тэрбум төгрөг буюу 16.0 хувиар дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.1 тэрбум, гадаад хандив тусламжийн орлого 13.2 тэрбум төгрөгөөр, нийтлэг татварын бус орлого 102.6 тэрбум төгрөгөөр; түүн дотроо хувьцааны ногдол ашиг 26.5 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 82.3 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 0.4 тэрбум, газрын тосны орлого 20.7 тэрбум төгрөгөөр, бусад орлого 7.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин хүүгийн орлого 25.4 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 2.4 тэрбум төгрөгөөр, навигацийн орлого 6.4 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

Татварын бус орлогын 86.3 хувийг нийтлэг татварын бус орлого, 13.6 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 40.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 12.7 хувийг хүүгийн орлого, 11.9 хувийг навигацийн орлого, 10.7 хувийг бусад орлого, 11.7 хувийг газрын тосны орлого, 10.5 хувийг торгуулийн орлого, 1.7 хувийг хувьцааны ногдол ашиг, 0.6 хувийг түрээсийн орлого тус тус эзэлж байна.



2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 11,263.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 83.8 хувийг ашиглаж 1,823.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 2,176.3 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар өсч 9,440.7 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,227.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 818.3 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 65.0 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 90.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,687.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 182.9 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 299.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 52.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны мөн үе | Төлөв. | Гүйц. | Төлөвлөгөө биелэлт, % | Өөрчлөлт | |
|---|------------------|----------|---------|-----------------------|----------|---------|
| | 2019.III | 2020.III | | Төлөв/Гүйцэт | Дүн | Хувь |
| | 1 | 2 | 3 | (3:2) | (3-1) | (3-1)/1 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 7,264.4 | 11,263.7 | 9,440.7 | 83.8% | 2,176.3 | 30.0 |
| НИЙТ ЗАРЛАГА | 7,103.8 | 11,174.2 | 9,427.3 | 84.4% | 2,323.5 | 32.7 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 5,783.5 | 5,819.6 | 5,050.8 | 88.8% | -732.7 | -12.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,699.5 | 2,626.3 | 2,164.2 | 85.4% | -535.3 | 19.8 |
| ХҮҮ | 627.1 | 669.7 | 578.8 | 86.4% | -48.3 | -7.7 |
| ТАТААС | 178.1 | 331.5 | 272.0 | 82.1% | 93.9 | 52.7 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,278.8 | 3,712.2 | 3,464.4 | 93.3% | 1,185.6 | 52.0 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,320.3 | 2,735.7 | 1,930.3 | 70.6% | 610.0 | 46.2 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 160.6 | 89.5 | 13.5 | 15.0% | -147.1 | -91.6 |

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 30.0 хувь буюу 2,176.3 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 147.1 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 1,713.4 тэрбум, хөрөнгийн зардал 610.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 48.4 тэрбум төгрөг буюу 7.7 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 90.9 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 7,497.0 тэрбум төгрөг буюу 79.4 хувь нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 42.4 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 46.2 хувийг урсгал шилжүүлэг, 7.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.6 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,713.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 48.4 тэрбум төгрөгөөр буурсан ч бараа, ажил үйлчилгээний зардал 482.4 тэрбум, татаас 93.9 тэрбум, урсгал шилжүүлэг 1,185.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл:

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,845.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -7.0 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 3,330.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол төлөвлөсөн дүнгээс 1,288.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төсвийн тэнцэл

| Хүснэгт 6. Үзүүлэлт | Жил бүрийн гуравдугаар улирлын байдлаар | | | | | /тэрбум төгрөг/ | |
|-----------------------------------|---|--------|-------|-------|----------|----------------------------------|----------|
| | | | | | | Өөрчлөлт(+/-) 2020.09/2019.09 | |
| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь |
| Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл | -2,051.7 | -737.9 | 241.7 | 484.6 | -2,198.0 | -2,390.2 | -1,243.6 |
| Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | -8.5 | -2.7 | 0.8 | 1.4 | -7.0 | - | - |

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2020 оны гуравдугаар улирлын байдлаар нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 771.1 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 301.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 56.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн бол, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 216.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2020 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 594.0 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 82.0 тэрбум төгрөг, дотоод зээлийн үндсэн төлбөрт 83.4 тэрбум төгрөг тус тус төлжээ. Харин 892.2 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл болон 834.4 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл шинээр авч, Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд шинээр гаргаагүй байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1 Гадаад худалдааны эргэлт:


2020 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт өнгөрсөн оны мөн үеэс 13.9 хувь буюу 1,469.7 сая ам.доллараар буурч 9,075.2 сая ам.долларт хүрсэн байна.

Гадаад худалдааны үзүүлэлт, /сая ам.доллар/

Хүснэгт 7.

| Үзүүлэлт | 09 дүгээр сар | | | | Өөрчлөлт | |
|-----------------------------|---------------|---------|----------|---------|----------|-------|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь |
| Нийт эргэлтийн бараа | 7,713.6 | 9,633.8 | 10,544.9 | 9,075.2 | -1,469.7 | -13.9 |
| -Экспорт | 4,582.9 | 5,282.8 | 5,946.1 | 5,147.0 | -799.1 | -13.4 |
| -Импорт | 3,130.8 | 4,351.1 | 4,598.8 | 3,928.1 | -670.7 | -14.6 |
| Тэнцэл | 1,452.1 | 931.7 | 1,347.3 | 1,218.9 | -128.4 | -9.5 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



Гадаад худалдааны тэнцэл: 2020 оны 3 улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл 1,218.9 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 128.4 сая ам.доллар буюу 9.5 хувиар буурахад экспортын 799.1 сая ам.доллар болон импортын 670.7 сая ам.долларын бууралт нөлөөлсөн байна.



Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2020 оны 9 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 49.5 сая ам.доллараар буурч 1,376.3 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл нийт бараа эргэлтийн 57.8% буюу 5,241.8 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 11.7% буюу 1,063.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 19.0%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 23.5%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 8.

| Улс | Төрөл | Эзлэх хувь | 3 дугаар улирлын гүйцэтгэл | | | Өөрчлөлт (+/-) | |
|-------|-------------|------------|----------------------------|-----------------------|-----------------------|-----------------|-------|
| | | | 2018 оны эхний 09 сар | 2019 оны эхний 09 сар | 2020 оны эхний 09 сар | 2020.09/2019.09 | |
| | | | | | | Дүн | Хувь |
| БНХАУ | Нийт эргэлт | 57.8 | 6,424.6 | 6,853.1 | 5,241.8 | -1,611.3 | -23.5 |
| | Экспорт | 73.5 | 4,920.7 | 5,305.7 | 3,781.2 | -1,524.5 | -28.7 |
| | Импорт | 37.2 | 1,503.9 | 1,547.4 | 1,460.6 | -86.8 | -5.6 |
| | Тэнцэл | | 3,416.8 | 3,758.3 | 2,320.6 | -1,437.7 | -38.3 |
| ОХУ | Нийт эргэлт | 11.7 | 1,314.3 | 1,312.1 | 1,063.3 | -248.8 | -19.0 |
| | Экспорт | 0.7 | 63.2 | 51.5 | 36.8 | -14.7 | -28.5 |
| | Импорт | 26.1 | 1,251.1 | 1,260.6 | 1,026.5 | -234.1 | -18.6 |
| | Тэнцэл | | -1,187.9 | -1,209.1 | -989.7 | 219.4 | -18.1 |
| Бусад | Нийт эргэлт | 30.5 | 1,895.0 | 2,379.8 | 2,770.1 | 390.3 | 16.4 |
| | Экспорт | 25.8 | 298.9 | 588.9 | 1,329.1 | 740.2 | 125.7 |
| | Импорт | 36.7 | 1,596.1 | 1,790.9 | 1,441.0 | -349.9 | -19.5 |
| | Тэнцэл | | -1,297.2 | -1,202.0 | -111.9 | 1,090.1 | -90.7 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цаг үеийн онцгой байдлаас шалтгаалж БНХАУ-тай хийх экспортын худалдаа 28.7 хувь буюу 1,524.5 сая ам.доллараар, ОХУ-тай хийсэн экспортын худалдаа 28.5 хувь буюу 14.7 сая ам.доллараар буурсан. Харин бусад орнуудтай хийсэн экспортын худалдаа 740.2 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

ОХУ-тай хийсэн импортын худалдаа 234.1 сая ам.доллар буюу 18.6 хувиар, БНХАУ-тай хийсэн импортын худалдаа 86.8 сая ам.доллар буюу 5.6 хувиар, бусад орнуудтай хийсэн импортын худалдаа 349.9 сая ам.доллар буюу 19.5 хувиар буурсан байна.

Монгол Улсын гадаад худалдаа БНХАУ-тай ашигтай, ОХУ болон бусад орнуудтай алдагдалдтай гарсан боловч нийт худалдааны алдагдал 2019 оны 9 дүгээр сартай харьцуулахад 9.5 хувиар буурсан байна.

3.2 Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын 70.3 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 29.7 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 3,616.9 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 1,345.2 сая ам.доллар буюу 27.1 хувиар буурсан бол, эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,530.1 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 546.1 сая ам.доллар буюу 55.6 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт, /сая ам.доллар/

Хүснэгт 9.

| Үзүүлэлт | 09 дүгээр сар | | | | Өөрчлөлт | | Нийт экспортод эзлэх хувь |
|--------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|---------------|--------------|---------------------------|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь | |
| Эрдсийн бүтээгдэхүүний экспорт | 3,649.9 | 4,538.5 | 4,962.6 | 3,616.9 | -1,345.7 | -27.1 | 70.3 |
| Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт | 933.0 | 744.3 | 983.5 | 1,530.1 | 546.6 | 55.6 | 29.7 |
| Нийт экспорт | 4,582.9 | 5,282.8 | 5,946.1 | 5,147.0 | -799.1 | -13.4 | 100.0 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2020 оны 09 сарын нийт экспортыг барааны бүлгээр авч үзвэл өмнөх оноос ихэнх бараа бүтээгдэхүүн буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс голлох буурсан бараа бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл эрдэс бүтээгдэхүүний экспорт 1,345.7 сая ам.доллараар, нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспорт 170.3 сая ам.доллараар, авто агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл 56.6 сая ам.доллараар, амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн 18.0 сая ам.доллараар тус тус буурсан байна. Харин үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс хэсэгт багтах барааны буюу Алтны экспорт 823.4 сая ам.доллараар, ургамлын гаралтай бүтээгдэхүүн 0.3 сая ам.доллараар өссөн байна.

Экспортын гүйцэтгэл, барааны бүлгээр

Хүснэгт 10.

| Барааны нэр | Экспорт | | Өөрчлөлт | | Бүтэц |
|--|---------|---------|----------|-------|-------|
| | 2019.09 | 2020.09 | мян.\$ | % | |
| 01 Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн | 45.2 | 27.2 | -18.0 | -39.8 | 0.5 |
| 02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн | 4.7 | 5.0 | 0.3 | 7.0 | 0.1 |

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

| | | | | | |
|--|----------------|----------------|-----------------|--------------|-------------|
| 03 Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх | 0.6 | 0.5 | -0.1 | -17.2 | 0.0 |
| 04 Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 44.6 | 36.8 | -7.8 | -17.5 | 0.7 |
| 05 Эрдэс бүтээгдэхүүн | 4,962.6 | 3,616.9 | -1,345.7 | -27.1 | 70.3 |
| 06 Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн | 1.2 | 0.4 | -0.8 | -65.1 | 0.0 |
| 07 Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс | 0.9 | 0.4 | -0.4 | -50.3 | 0.0 |
| 08 Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 11.8 | 6.5 | -5.2 | -44.4 | 0.1 |
| 09 Мод, модон эдлэл | 0.6 | 0.3 | -0.3 | -47.8 | 0.0 |
| 10 Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс | 0.0 | 0.0 | 0.0 | 87.7 | 0.0 |
| 11 Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл | 388.8 | 218.5 | -170.3 | -43.8 | 4.2 |
| 12 Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл | 1.6 | 1.1 | -0.5 | -30.2 | 0.0 |
| 13 Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн | 0.1 | 0.1 | 0.0 | 45.3 | 0.0 |
| 14 Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос /Алт/ | 344.9 | 1,168.4 | 823.4 | 238.7 | 22.7 |
| 15 Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн | 49.7 | 39.5 | -10.2 | -20.6 | 0.8 |
| 16 Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг | 26.5 | 19.8 | -6.8 | -25.5 | 0.4 |
| 17 Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги | 59.9 | 3.2 | -56.6 | -94.6 | 0.1 |
| 18 Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги | 0.7 | 1.0 | 0.3 | 47.0 | 0.0 |
| 19 Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа | 1.8 | 1.4 | -0.5 | -25.5 | 0.0 |
| 20 Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс | 0.1 | 0.0 | 0.0 | -92.7 | 0.0 |
| ДҮН | 5,946.1 | 5,147.0 | -799.0 | -13.4 | 100 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хураамжийн орлого

Хүснэгт 11.

/мянган тонн, сая төгрөг/

| Экспортын эрдэс бүтээгдэхүүний гол нэрийн бараа | Эхний 09 сар | | | | Өөрчлөлт | |
|---|--------------|------------------|------------|------------------|------------|-------------------|
| | 2019 он | | 2020 он | | 2020/2019 | |
| | Тоо хэмжээ | Хураамж | Тоо хэмжээ | Хураамж | Тоо хэмжээ | Хураамж |
| Жонш | 500.00 | 750.00 | 490.74 | 736.10 | -9.26 | -13.90 |
| Төмрийн хүдрийн баяжмал | 6,134.30 | 9,201.50 | 6,252.54 | 9,378.82 | 118.24 | 177.32 |
| Зэсийн баяжмал | 1,066.30 | 1,599.40 | 1,020.74 | 1,531.11 | -45.56 | -68.29 |
| Цайрын баяжмал | 100.70 | 151.00 | 102.72 | 154.08 | 2.02 | 3.08 |
| Чулуун нүүрс | 28,628.90 | 42,943.30 | 19,821.43 | 29,732.15 | -8,807.47 | -13,211.15 |
| Хүрэн нүүрс | 115.00 | 172.40 | 46.31 | 69.47 | -68.69 | -102.93 |
| Түүхий нефть/мянган баррель/ | 4,842.00 | 7.30 | 2,379.67 | 3.57 | -2,462.33 | -3.73 |
| Бусад | | 147.40 | | 10.48 | | -136.92 |
| Нийт | | 54,972.30 | | 41,615.77 | | -13,356.53 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Улсын төсөвт хураамжийн орлогоор 54.5 тэрбум төгрөг оруулах төлөвлөгөөтэйгөөс 43.8 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөний гүйцэтгэл 80.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн 12.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Экспортоор гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн 95.2 хувийг эзэлж байна.

Үүнээс:

- Чулуун нүүрс 19.8 сая тонн - 29.7 тэрбум төгрөг,
- Зэсийн баяжмал 1020.7 мянган тонн – 1.5 тэрбум төгрөг,
- Төмрийн хүдрийн баяжмал 6.2 сая тонн –9.3 тэрбум төгрөгийг тус тус хураамжийн орлогод төвлөрүүлжээ.

Экспорт өмнөх оны мөн үеэс 799.0 сая америк доллараар буурахад зэсийн баяжмалын экспорт 254.7 сая америк доллар, нүүрсний экспорт 961.2 сая америк доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Улсын онцгой комиссын 2020-02-10-ны 4 дүгээр хуралдаанаар Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс тээвэрлэлтийг 2020-03-02-ны өдрийг хүртэл зогсоож, холбогдох арга хэмжээг авах шийдвэр гарсан тул экспортоор гаргасан нүүрсний тоо хэмжээ 2020 оны эхний 09 сард 19.8 сая тонн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс /8.8 сая тонн/ 30.8 хувиар буурахад нөлөөлсөн байна.

3.3 Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Импорт: 2020 оны 3 улирлын байдлаар импортын хэмжээ 3,928.1 сая ам.долларт хүрч, 2019 оны мөн үеэс 670.7 сая ам.доллар буюу 14.6 хувиар буурсан байна.

Нийт импортын 18.5 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 81.5 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 728.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 288.9 сая ам.доллараар буюу 28.4 хувиар, эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 3,200.1 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 381.8 сая ам.доллар буюу 10.7 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт, /сая ам.доллар/

Хүснэгт 12.

| Үзүүлэлт | 09 дүгээр сар | | | | Өөрчлөлт | | Нийт импортод эзлэх хувь |
|-----------------------------------|----------------|----------------|----------------|----------------|---------------|--------------|--------------------------|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь | |
| Эрдсийн бүтээгдэхүүний импорт | 737.6 | 976.0 | 1,016.9 | 728.0 | -288.9 | -28.4 | 18.5 |
| Эрдсээс бусад бүтээгдэхүүн импорт | 2,393.2 | 3,375.1 | 3,581.9 | 3,200.1 | -381.8 | -10.7 | 81.5 |
| Нийт импорт | 3,130.8 | 4,351.1 | 4,598.8 | 3,928.1 | -670.7 | -14.6 | 100.0 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт импорт буурахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

- Эдийн засгийн идэвхжилт буурч байгаатай холбоотойгоор уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбаруудын үйл ажиллагаа

агшиж үйлдвэрлэлийн орц, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, эд ангийн импорт буурсан;

- Дэлхийн зах зээл дэх түүхий нефтийн биржийн үнийн бууралтаас хамаарч шатахууны хилийн үнэ 25 гаруй хувиар буурсан;
- Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн “Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” 39 дүгээр тогтоолын дагуу Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын хөдөлгөөнд хязгаарлалт хийгдсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

Хүснэгт 13.

/сая ам.доллар/

| Бүтээгдэхүүн | 3 дугаар улирлын гүйцэтгэл | | | | | | Өөрчлөлт Сая ам.дол 2020/2019 |
|--|----------------------------|---------------|----------------|---------------|----------------|---------------|-------------------------------------|
| | 2018 | | 2019 | | 2020 | | |
| | Сая ам.дол | Эзлэх хувь | Сая ам.дол | Эзлэх хувь | Сая ам.дол | Эзлэх хувь | |
| Хэрэглээ | 1,182.0 | 27% | 1,230.0 | 27.0% | 1,109.0 | 28.0% | -121 |
| - Түргэн эдэлгээтэй | 617.0 | 14.0% | 621.0 | 14.0% | 629.0 | 16.0% | 8 |
| - Удаан эдэлгээтэй | 565.0 | 13.0% | 609.0 | 14.0% | 480.0 | 12.0% | -129 |
| Хөрөнгө оруулалт | 1,798.0 | 41.0% | 1,999.0 | 43.0% | 1,749.0 | 45.0% | -250 |
| - Машин, механик тоног төхөөрөмж, эд анги | 1,127.0 | 26.0% | 1,314.0 | 29.0% | 1,076.0 | 27.0% | -239 |
| - Барилгын материал | 512.0 | 12.0% | 523.0 | 11% | 480.0 | 12.0% | -43 |
| - Хөрөнгө оруулалтын бусад бараа | 157.0 | 4.0% | 161.0 | 4.0% | 193.0 | 5.0% | 32 |
| Аж үйлдвэрлэлийн орц | 553.0 | 13.0% | 507.0 | 11.0% | 483.0 | 12.0% | -24 |
| - Цахилгаан эрчим хүч | 105.0 | 2.0% | 108.0 | 2.0% | 104.0 | 3.0% | -3 |
| Нефтийн бүтээгдэхүүн | 815.0 | 19.0% | 858.0 | 19.0% | 583.0 | 15.0% | -275 |
| - Дизель | 414.0 | 10.0% | 507.0 | 11.0% | 305.0 | 8.0% | -203 |
| - АИ-92, 95 | 191.0 | 4.0% | 211.0 | 5.0% | 158.0 | 4.0% | -53 |
| - А80 ба бусад | 210.0 | 5.0% | 140.0 | 3.0% | 121.0 | 3.0% | -19 |

Эх сурвалж: Монголбанк

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15%-иар буюу 671 сая ам.доллараар буурав. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл нефтийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт голлон нөлөөлсөн байна.

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2020 оны гуравдугаар улирлын байдлаар 22,425.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1,993.0 тэрбум төгрөг буюу 9.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 2,236.8 тэрбум төгрөгөөр буюу 13.5 хувиар өссөн нь нөлөөлсөн. Үүн дотроо төгрөгийн хадгаламж 862.7 тэрбум төгрөг буюу 8.0 хувиар, валютын хадгаламж 2,185.5 тэрбум төгрөг буюу 74.7 хувиар тус тус өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

Хүснэгт 14.

| Үзүүлэлт | 3 дугаар улирлын гүйцэтгэл | | | | Өөрчлөлт (+/-) 2020.09/2019.09 | |
|-------------------------------------|---------------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------------------------|----------------|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь |
| | Мөнгөний нийлүүлэлт (M2) | 14,749.7 | 17,920.2 | 20,432.9 | 22,425.9 | 1,993.0 |
| Бараг мөнгө | 11,949.3 | 14,497.1 | 16,628.6 | 18,865.4 | 2,236.8 | 13.5% |
| - Төгрөгийн хадгаламж | 7,427.7 | 9,512.8 | 10,780.8 | 11,643.5 | 862.7 | 8.0% |
| - Валютын хадгаламж | 2,601.6 | 2,709.9 | 2,925.0 | 5,110.5 | 2,185.5 | 74.7% |
| - Валютын харилцах | 1,920.0 | 2,274.4 | 2,922.8 | 2,111.4 | -811.4 | -27.8% |
| M1 мөнгө | 2,800.4 | 3,423.1 | 3,804.3 | 3,560.5 | -243.8 | -6.4% |
| Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө | 878.9 | 929.1 | 889.8 | 950.1 | 60.3 | 6.8% |

Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 09 дүгээр сарын эцэст 17,348.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 803.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл

Хүснэгт 15.

| Үзүүлэлт | 3 дугаар улирлын гүйцэтгэл | | | | Өөрчлөлт (+/-) 2020.09/2019.09 | |
|---|-------------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------------------------|---------------|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | Дүн | Хувь |
| | Зээлийн өрийн үлдэгдэл | 13,421.4 | 16,342.4 | 18,152.2 | 17,348.5 | -803.6 |
| - Хэвийн зээл | 11,424.9 | 13,991.9 | 15,193.7 | 14,230.3 | -963.4 | -6.3% |
| - Хугацаа хэтэрсэн зээл | 827.0 | 991.0 | 985.6 | 1,147.1 | 161.5 | 16.4% |
| - Чанаргүй зээл | 1,169.5 | 1,359.4 | 1,972.9 | 1,971.1 | -1.7 | -0.1% |
| Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх % | 8.7 | 8.3 | 10.9 | 11.4 | 0.5 | 4.5% |
| Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх % | 6.2 | 6.1 | 5.4 | 6.6 | 1.2 | 21.8% |

Эх сурвалж: Монголбанк


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 09 дүгээр сарын эцэст 1,147.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 161.5 тэрбум төгрөг буюу 16.4 хувиар өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.6 хувь, хэвийн зээлийн 8.1 хувийг тус тус эзэлжээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 3 дугаар улирлын эцэст 1,971.1 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.7 тэрбум төгрөг буюу 0.1 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.4 хувь, хэвийн зээлийн 13.9 хувийг эзэлсэн байна. Нийт чанаргүй зээлийн 74.3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зээл, 24.9 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна.


Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2020 оны 09 дүгээр сарын эцэст нийт **210.1** сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, **34.8** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 73.2 хувиар буурсан байна. Харин 09 дүгээр сарын эцэст Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар **586.9** сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2020 оны 09 дүгээр сард **17,176.2** нэгж болж өмнөх оны мөн үеэс 2,141.3 нэгж буюу 11.1 хувиар буурчээ.

Валютын ханш: 2020 оны 09 дүгээр сарын эцэст Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,854.2 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.1 хувиар, оны эхнээс 3.7 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 419.0 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар оны эхнээс 5.7 хувиар суларсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 09 дүгээр сарын эцэст 1.7 хувь болж өмнөх сараас 0.4 пунктээр, өмнөх оны мөн үеэс 7.3 пунктээр тус тус буурсан байна.



Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц:

Гадаад валютын нөөцийн хэмжээ 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 3,697.8 сая ам.долларт хүрээд байна. Нөөц хэмжээ өмнөх оны мөн үеэс 287.8 сая ам.доллар буюу 7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2020 оны 09 дүгээр сарын байдлаар 3,697.8 сая ам.доллар буюу 3 сарын дунджаар тооцсон импортын 9.1 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ 15.0 хувиар, гадаад валютын албан нөөц 13.3 хувиар тус тус буурч харин импортын сарын хэрэгцээг хангах түвшин өмнөх оны мөн үеэс 2.4 пунктээр өссөн байна.

Гадаад валютын албан нөөц ба импорт

Хүснэгт 16.

/сая ам.доллар/

| № | Үзүүлэлт | 2015.09 | 2016.09 | 2017.09 | 2018.09 | 2019.09 | 2020.09 |
|---|---|------------|------------|------------|------------|------------|------------|
| 1 | Нийт импорт | 2,856.7 | 2,448.0 | 3,124.7 | 4,351.1 | 4,598.8 | 3,928.1 |
| 2 | Гадаад валютын нийт нөөц | 1,412.7 | 1,092.4 | 1,627.0 | 2,894.0 | 3,985.6 | 3,697.8 |
| 3 | <i>Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/</i> | <i>4.6</i> | <i>3.8</i> | <i>4.4</i> | <i>5.8</i> | <i>7.3</i> | <i>7.8</i> |

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 17.1 тонн болж, өмнөх оны мөн үеэс 6.0 тонноор өссөн байна.



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2020 оны гуравдугаар улирлын байдлаар урсгал тэнцэл 741.6 сая ам.долларын, төлбөрийн тэнцэл 472.5 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

2020 оны 3 дугаар улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал 741.6 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 265.3 сая ам.доллар гарсан бол харин бараа ба үйлчилгээ 173.1 сая ам.доллар, цэвэр орлого 833.8 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 453.1 сая ам.доллараар буурсан байна. Урсгал тэнцлийн алдагдал буурахад бараа ба үйлчилгээний худалдааны алдагдал 98.8 сая ам.доллараар, орлого 284.6 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ.

2020 оны 3 дугаар улирлын байдлаар хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 391.3 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 1,148.9 сая ам.доллараар буурсан байна. Төлбөрийн тэнцэл 472.5 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 736.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Төлбөрийн тэнцэл

Хүснэгт 17.

/сая ам.доллар/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл | | | 3 дугаар улирлын өөрчлөлт (+/-) | |
|---|-----------------|-----------------|---------------|---------------------------------|-----------------|
| | 2018.I-IX | 2019.I-IX | 2020.I-IX | 2019/2018 | 2020/2019 |
| I. Урсгал Тэнцэл | -1,386.4 | -1,194.7 | -741.6 | 191.7 | 453.1 |
| А. Бараа ба үйлчилгээний худалдаа | -765.5 | -271.9 | -173.1 | 493.6 | 98.8 |
| В. Орлого | -874.0 | -1,118.4 | -833.8 | -244.4 | 284.6 |
| С. Урсгал шилжүүлэг (цэвэр) | 253.1 | 195.6 | 265.3 | -57.5 | 69.7 |
| II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл | 1,129.9 | 1,540.2 | 391.3 | 410.3 | -1,148.9 |
| А. Хөрөнгийн данс | 62.7 | 83.3 | 72.3 | 20.6 | -11.0 |
| В. Санхүүгийн данс | 1,067.2 | 1,456.9 | 319.0 | 389.7 | -1,137.9 |
| III. Алдаа болон орхигдуулга | -218.8 | -81.1 | -122.3 | 137.7 | -41.2 |
| Төлбөрийн тэнцлийн нийт дүн | -475.3 | 264.3 | -472.5 | 739.6 | -736.8 |

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хүн ам, ажил эрхлэлт:


2019 онд Монгол Улсын хүн ам 3,296.9 мянга, өрхийн тоо 897.4 мянгад хүрчээ. Улсын хэмжээнд 2020 оны гуравдугаар улиралд 57.1 мянган эх амаржиж, 57.5 мянган хүүхэд шинээр төрж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 1.0 мянга буюу (1.8%)-аар, төрсөн хүүхэд 1.0 мянга (1.8%)-аар тус тус буурчээ.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 09 дүгээр сарын эцэст 27.5 мянга, үүнээс 17.8 (64.8%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 9.7 (35.2%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 12.7 хувь буюу 2.6 мянгаар буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.8 хувь нь бүрэн дунд, 21.4 хувь нь дипломын дээд болон бакалаврын, 13.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.9 хувь нь суурь, 2.7 хувь нь бага, 0.8 хувь нь магистр, доктор, 1.6 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 54.8 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС